

## Банкны салбарын эргэн тойронд

10.06 – Монголын банкны холбооны гишүүн арилжааны 13 банк болон Монгол Улсын хөгжлийн банк “Банкинд комплаенсийн бодлого нэвтрүүлэх, чиг үүрэг тодорхойлох үлгэрчилсэн загвар” зааврын хэрэгжилтийг дэмжиж, өөрийн банкны үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжүүлэхээ батлан Комплаенсийг хэрэгжүүлэх тунхаг бичигт гарын үсэг зурлаа. [mba.mn](http://mba.mn)

10.17 – Голомт банк БНХАУ-ын Bank of Inner Mongolia-тай хоёр улсын гадаад худалдааг нэмэгдүүлэх, экспорт импортлогчдыг дэмжих зорилготой 15 сая ам.долларын худалдааны санхүүжилтийн зээлийн гэрээг байгуулав. [golomtbank.com](http://golomtbank.com)

10.27 – Монголбанк 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (ТТҮЗ)-ийн ээлжит XVI хуралдааныг зохион байгуулж, гишүүн байгууллагуудад “Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги”-ийн баримт бичгийг албан ёсоор танилцууллаа. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

11.07 – Монголын банкны холбоо, Хаан банк болон Монголбанк хамтран “Комплаенс Форум 2016” арга хэмжээг 4 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Форумын зорилго нь Монгол Улсын арилжааны банкуудын комплаенсийн үйл ажиллагаа, түүний хөгжил ямар түвшинд байгааг ярилцан, гарч буй асуудлуудыг тодорхойлж, ямар нэгэн шийдэлд хүрэн явдал юм. [mba.mn](http://mba.mn)

11.13 – Азийн банк, санхүү болон хөрөнгө оруулагчдын тэргүүлэх сэтгүүл болох “FinanceAsia” 20 жилийн ойн баярын ёслолын арга хэмжээний үеэр ХХБ-ыг “Монгол Улсын Шилдэг банк”-р өргөмжилжээ. [tdbm.mn](http://tdbm.mn)

11.15 – Олон улсын төлбөрийн системээр дэлхийд тэргүүлэгч Visa Worldwide байгууллага ХХБ-тай хамтарсан 24 жилийн амжилттай түншлэл, хамтын ажиллагаагаа үнэлэн “Deep partnership”-р тодруулж, шагнал гардуулав. [tdbm.mn](http://tdbm.mn)

11.17 – Төрийн банк автомат хуримтлалын үйлчилгээг нэвтрүүлэв. Автомат хуримтлалын үйлчилгээ нь харилцагч таны төгрөгийн данснаасаа хийж буй 5000 төгрөгөөс дээш дүнтэй төлбөрийн гүйлгээний бутархай дүнг мянгатаар бүхэлдэн тооцож, зөрүү дүнг хуримтлалын дансанд автоматаар шилжүүлэн хуримтлал үүсгэх үйлчилгээ юм. [statebank.mn](http://statebank.mn)

11.17 – Төрийн банк зах зээлд анх удаа олон улс болон дотоодод төлбөр тооцоонд ашиглах, картын нууцлал, аюулгүй байдлын стандартад нийцсэн JCB нэрийн төгрөг болон ам.долларын сонголттой дебит карт гаргалаа. Ингэснээр Монгол Улс JCB картыг гүйлгээнд гаргаж буй 21 дэх орон болж байна. [statebank.mn](http://statebank.mn)

11.24 – “Тогтвортой санхүүжилтийн форум 2016”-ын үеэр Ариг банк 2017 оны Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн манлайлагч байгууллагаар сонгогдож, шилжин явах туг хүлээн авав. [arigbank.mn](http://arigbank.mn)

11.25 – Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн форум 2016 амжилттай зохион байгуулагдлаа. Уг форумд төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын 400 орчим төлөөлөгч оролцож, өнгөрсөн хугацаанд тус хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хамтын ажиллагааны чиглэлүүдийн талаар ярилцав. [mba.mn](http://mba.mn)

11.27 – Голомт банкны Зэс кредит картыг “Виза” олон улсын байгууллага “Оны шилдэг инновацитай бүтээгдэхүүн”-р тодруулав. [golomtbank.com](http://golomtbank.com)

12.15 – Монголын банкны холбоо 11 дэх жилдээ бүх гишүүдээ оролцуулсан чуулганаа зохион байгууллаа. Чуулганы үеэр холбооны ерөнхийлөгч О.Орхон болон дэд ерөнхийлөгч Д.Төмөрхүү нарын бүрэн эрхийн хугацааг 1 жилээр сунгав. [mba.mn](http://mba.mn)

12.20 – Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл 2016 оны 12-р сарын 19-ний өдөр хуралдаж бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 14 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

## Банкны салбарын гол үзүүлэлтүүд


Банкны салбарын актив, их наяд төгрөг



**Нийт актив = 25,3 их наяд төгрөг**

Банкны салбарын нийт актив 2016 оны 4-р улиралд 25,3 их наяд төгрөг болж өмнөх улирлаас даруй 0,7 их наяд төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4 их наяд төгрөгөөр өслөө. 2015 оны 3-р улирлаас хойш улирал бүр банкны салбарын нийт актив өслөө.


Нийт зээл ба чанаргүй зээлийн эзлэх хувь



**Чанаргүй зээл 8.1%-д хүрлээ**

Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2014 оны 2-р улирлаас хойш 2016 оны 4-р улирал хүртэл тогтмол өслөө. 2014 оны 2-р улиралд чанаргүй зээл 2,8% байсан бол 2016 оны 4-р улиралд 8,1% буюу 2,9 дахин ихэсжээ. Нийт дүнгээр авч үзвэл нийт чанаргүй зээл 1 их наяд төгрөгт хүрээд байна.


Ипотекийн зээл, их наяд төгрөг



**Ипотекийн зээл = 4.0 их наяд төгрөг**

Нийт ипотекийн зээл 4 их наяд төгрөг хүрсэн бол үүнээс орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр (ОСИСТТБ)-н дагуу 3,1 их наяд төгрөгний зээл олгосон байна. Ипотекийн зээлийн хэмжээ тус хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш тогтмол өссөөр байна.

Хадгаламж ба харилцах, их наяд төгрөг



**Харилцах+Хадгаламж=11,4 их наяд ₮**

Нийт банкны салбарын харилцах ба хадгаламжийн нийлбэр өмнөх оны мөн үеэс 20% буюу 1,9 их наяд төгрөгөөр өсөөд байна. Харин өмнөх улирлаас 0,5 их наяд төгрөгөөр өсжээ. 2015 оны 3-р улирлаас харилцах ба хадгаламжийн нийлбэр дүн улирал бүр тогтмол өсчээ.


# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2016 он – IV улирал




## Валют(Харилцах + Хадгаламж) = 4,2 их наяд ₮

Банкны салбарын валютын харилцах болон хадгаламжийн хэмжээ өмнөх улиралтай харьцуулахад валютын харилцах 34,6%-иар харин валютын хадгаламж 15,2%-иар өссөн байна. Нийт валютын харилцах ба хадгаламжийн нийлбэр өмнөх оны мөн үеэс 21,6% өсөж 3,82 их наяд төгрөгт хүрээд байна.




1\$=2482₮ 1¥=358₮

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2016 оны 6 сарын дундаж Ам.доллар-ын ханш 2482₮ болж огцом өссөн бол Юань-ийн ханш 358₮ байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.доллар 487₮-р, Юань 49₮-р өссөн үзүүлэлт юм. Энэхүү ханшийн огцом өсөлтөөс үүдэн Монголбанк бодлогын хүүг 15%-д хүргээд байсан бол ханш тогворжсоны дараа 14% болгон бууруулсан.



## Ашиг = 177 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2016 оны 4-р улирлын байдлаар 2,9 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 21% өслөө. 2016 оны 4-р улирлын байдлаар банкны салбарын ашиг 177 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийн ашгаас 49 тэрбум төгрөгөөр бага үзүүлэлт юм.



## Банкны нөөц = 2.6 их наяд төгрөг

Банкны нөөц 2016 оны 1 сараас 6-р сар хүртэл тогтмол өсч 3 их наяд төгрөгт хүрээд байсан хэдий ч 9-р сарын байдлаар 2,6 их наяд төгрөг хүрч буурлаа. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24% өссөн үзүүлэлт юм.



## Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2016 оны 4-р улирлын байдлаар банкны салбарт нийт 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Нийт актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан

Энэ удаагийн тайланд Капитал болон Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.



### АКТИВ

### БАНКУУД

ТОМ-3 БАНК	>3 их наяд төгрөг	Худалдаа хөгжлийн банк Хаан банк Голомт банк
ДУНД-3 БАНК	1-3 их наяд төгрөг	Хасбанк Төрийн банк Улаанбаатар хотын банк
БУСАД БАНКУУД	<1 их наяд төгрөг	Капитал банк Чингис хаан банк Капитрон банк Үндэсний хөрөнгө оруулалтын банк Ариг банк Богд банк Кредит банк Тээвэр хөгжлийн банк

## Арилжааны банкуудын зээл олголт<sup>1</sup>

Арилжааны банкууд 2016 оны 4-р улиралын эцсийн байдлаар 12,6 их наяд төгрөгийн зээл олгосон байна. Үүнээс 83% нь хугацаандаа хэвийн төлөгдөж байгаа бол үлдсэн зээл нь хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу гэсэн 4 зээлийн ангилалд байна.

Хугацаандаа хэвийн төлөгдөж буй зээл 10,5 их төгрөг байгаагаас 6 их наяд төгрөгийн зээл нь 1-5 хүртэл жилийн хугацаатай зээл байна. Харин богино хугацааны буюу 1 хүртэл жилийн хугацаатай 2,1 их наяд төгрөгийн зээл байгаа бол 5-с дээш жилийн хугацаатай 2,4 их наяд төгрөгийн зээл байна.

Зээл, тэрбум төгрөгөөр




Зээл, эргэн төлөлтийн хугацаагаар, тэрбум төгрөг



Арилжааны банкууд нь томоохон салбаруудыг зээлээр санхүүжүүлж эдийн засгийг дэмждэг билээ. Банкууд ямар салбаруудад зээл ихээр олгогдгийг доорх графикаас та харж болно. Цалин, тэтгэвэр, хэрэглээний төрлийн зээлүүд нь хамгийн их хувь эзэлж байгаа бөгөөд энэ төрлийн зээлүүдийн 96% нь хугацаандаа хэвийн төлөгдөж байна.

Бөөний болон жижиг худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхайн салбарууд мөн их хэмжээний зээлийг банкуудаас авдаг. Харин уул уурхайн салбарын зээлийн дөнгөж 35% нь хугацаандаа төлөгдөж байна.

Томоохон салбаруудад олгосон зээл, тэрбум төгрөгөөр




<sup>1</sup> Энд Монголбанкнаас гаргадаг арилжааны банкны зээлийн тайланг ашигласан.

## АКТИВ



Тайлант хугацаанд тайланд орсон 12 банкны нийт актив 25.3 их наяд төгрөгт хүрлээ. Том-3 банк нийт активын 72.3 хувийг эзэлж буй буюу өмнөх улирлаас 0.7 нэгжээр нэмэгдсэн бол Дунд-3 банк 23.1 хувь, жижиг банкууд 4.6 хувийг эзэлж байна.

ХХБ хамгийн их активтай буюу 6,6 их наяд төгрөгийн активтай байгаа бол Кредит банк 17 тэрбум төгрөгийн активтай буюу хамгийн бага нь байна.


Зах зээлд эзлэх хувь, активаар, 4У'16



## Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь




## Жижиг банкууд





## ЗЭЭЛ

Тайланд орсон 12 банкны нийт зээл 11,5 их наяд төгрөг байна. Үүнээс 70.4%-г Том-3 банк, 24.9%-г Дунд-3 банк, 4.7%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Хаан банк зээл олголтын хэмжээгээрээ ХХБ-ыг гүйцлээ. Хаан банкны нийт зээлийн хэмжээ 3,1 их наяд төгрөг байгаа бол ХХБ-ны нийт зээлийн хэмжээ 2,9 их төгрөг байгаа нь өмнөх улирлаас 0,3 их наяд төгрөгөөр буурсан үзүүлэлт юм. Харин Хаан банкны зээлийн хэмжээ 0,1 их наяд төгрөгөөр өсжээ.




## Зээлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь






## ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ

Тайланд орсон нийт 12 банкны харилцах ба хадгаламжийн 71,3%-г Том-3 банк, 24%-г Дунд-3 банк, 4,7%-г бусад 6 жижиг банкууд эзэлж байна.

Эдгээр банкуудын нийт харилцах болон хадгаламжийн хэмжээ 12,47 их наяд төгрөгт хүрээд байна. Үүнээс 3,1 их наяд төгрөг нь Хаан банкны харилцах болон хадгаламжийн хэмжээ юм. Харилцах ба хадгаламжийн нийт дүнгээр Хаанбанк 30,9%-г эзэлж буй нь тэргүүлэх үзүүлэлт юм.



## Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт







## АШИГ

2016 оны эцсийн байдлаар тайланд орсон 12 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 224,8 тэрбум төгрөгийн ашигтай (татварын дараах дүн) ажиллажээ. Энэ дүн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 хувь буурсан үзүүлэлт юм.

Банкуудын ашиг, алдагдал:



Эх үүсвэр:

1. Статистикийн бюллетень, Монголбанк
2. Ипотекийн зээлийн тайлан, Монголбанк
3. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк
4. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
5. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан
6. Арилжааны банкны зээлийн тайлан, Монголбанк